

Мансууруулах бодистой холбоотой асуудлын улмаас ял эдэлж буй хоригдогсдын дундах БЗДХ-ыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээний зарим үр дүн

Э.Минжмаа¹, Н.Билгүүн¹, Д.Оюунсүрэн¹, Х.Тэргэл¹, Ж.Даваалхам², З.Хишигсүрэн¹¹АШУУИС АУС-ийн Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхим²ХӨСҮТ, ХДХВ/БЗДХ-ын Тандалт судалгааны алба

Цахим шуудан: Dr.minjmaa87@gmail.com, Утас: 99711658

Түлхүүр үг:

хоригдол,
мансууруулах бодис
хэрэглэгч
тэмбүү
ХДХВ
түргэвчилсэн

Товч утга

Үндэслэл: Мансууруулах бодисын хэрэглээ нь бэлгийн замаар дамжих халдвар, ялангуяа тэмбүү, ХДХВ-ийн халдварт өртөх эрсдэлтэй нягт холбоотой нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал юм. Мансууруулах бодистой холбоотой асуудлын улмаас хорих ангид ял эдэлж буй хүмүүс нь бэлгийн эрсдэлт зан үйл, олон төрлийн бодисын хэрэглээ, эрүүл мэндийн үйлчилгээний хязгаарлагдмал байдлаас шалтгаалан БЗДХ-ын эрсдэл өндөр бүлэгт хамаардаг. **Зорилго:** Мансууруулах бодистой холбоотой асуудлын улмаас хорих ангид ял эдэлж буй хоригдогсдын дундах мансууруулах бодисын хэрэглээний байдал, БЗДХ-ыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээний үр дүнг тогтооход оршино. **Арга, аргачлал:** Судалгааг агшингийн аналитик загвараар хийж, 105 хоригдлыг хамруулав. Судалгааг судалгааны багийн боловсруулсан асуумж болон БЗДХ-ыг илрүүлэх түргэвчилсэн оношлуурыг ашиглан судалгааны мэдээлэл цуглуулсан. Өгөгдлийг Microsoft Excel болон SPSS 23 программд боловсруулж, давтамж, хувь, дундаж, стандарт хазайлт, χ^2 болон Fisher-ийн exact тестийг ашиглан шинжилсэн, $p < 0.05$ -ыг статистикийн ач холбогдолтойд тооцлоо. **Үр дүн:** Судалгаанд хамрагдсан хоригдлуудын дундаж нас 29.1 ± 8.4 жил, 78.1% нь эрэгтэй, 55.2% нь 25–34 насныхан байв. Оролцогчдын 16.2% нь өмнө нь БЗДХ-т өвчнөөр өвдөж байсан, 19.0% нь сүүлийн 12 сард БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн, 39.0% нь сүүлийн 12 сард БЗДХ-ын шинжилгээ өгсөн, 45.7% нь ял эдэлж байх хугацаандаа БЗДХ-ын шинжилгээнд хамрагдсан, 79.0% нь БЗДХ-ын талаарх сургалтанд хамрагдсан байлаа. БЗДХ-ыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээнд хамрагдагсдын 81 оролцогчийн хариу хүчинтэй байснаас 27 тохиолдолд эерэг байгаа нь 33.3%-ийг эзэлж байв. Мансууруулах бодисыг нэгээс дээш аргаар хэрэглэдэг хүмүүсийн бүлэгт тэмбүүгийн түргэвчилсэн шинжилгээ эерэг байх хувь 41.4% байсан нь нэг аргаар хэрэглэдэг бүлгийн (13.0%)-хээс статистикийн ач холбогдолтой өндөр байв ($p = 0.018$). Мөн өмнө нь БЗДХ-аар өвдөж байсан түүхтэй оролцогчдын 70.0%-д тэмбүүгийн түргэвчилсэн шинжилгээ эерэг гарсан нь БЗДХ-ын түүхгүй бүлгээс 26.6%-иар статистикийн ач холбогдолтой өндөр байлаа ($p = 0.011$). Харин хүйс, нас, боловсрол, гэрлэлтийн байдал, орлогын байдал, тариур хэрэглэх болон сүүлийн 12 сард БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн байдалтай статистикийн ач холбогдол бүхий үзүүлэлт илрээгүй. **Дүгнэлт:** Мансууруулах бодистой холбоотой асуудлын улмаас хорих ангид ял эдэлж буй хоригдлуудын дунд БЗДХ-ын илрүүлгийг тогтмол хийх, олон төрлийн мансууруулах бодис, олон аргаар хэрэглэгчид болон өмнө нь БЗДХ-аар өвдөж байсан түүхтэй хүмүүст чиглэсэн эрт илрүүлэг, зөвлөгөө, эмчилгээг сайжруулах шаардлагатай байна.

Үндэслэл: Мансууруулах бодисын хэрэглээ нь дэлхий нийтийн хэмжээнд эрүүл мэнд, нийгэм, хууль зүйн тулгамдсан асуудлын нэг хэвээр байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд хэрэглэгчдийн тоо өсөхийн зэрэгцээ халдварт өвчин, сэтгэцийн эмгэг, гэмт хэрэг зэрэг нийгмийн сөрөг үр дагавар нэмэгдэж байна.¹ Мансууруулах бодис хэрэглэгчид мансуурсан үедээ өөртөө шүүмжлэлтэй хандах, шийдвэр гаргах чадвар буурах, хамгаалалтгүй болон тохиолдлын бэлгийн хавьталд орох, олон хавьтагчтай байх, зарим тохиолдолд мансууруулах бодисыг тарьж хэрэглэхдээ зүү тариурыг дамжуулан хэрэглэх зэргээс шалтгаалан БЗДХ, ХДХВ, вируст гепатитын халдвар авах эрсдэл өндөр бүлэгт хамаардаг.²⁻⁷

Монгол Улсад 2023 оны жилийн эцсийн байдлаар ХДХВ/ДОХ-ын 369 тохиолдол бүртгэгдэж, тэмбүүгийн 4206 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлт байв.²

Мансууруулах болистой холбоотой асуудлын улмаас хорих ангид ял эдэлж буй хоригдлууд нь мансууруулах бодисыг хэрэглэх арга, өмнө нь холбогдсон гэмт хэрэг, нийгэм-эдийн засгийн байдал, эрүүл мэндийн үйлчилгээний хүрэлцээ, бэлгийн эрсдэлт зан үйлээс шалтгаалан БЗДХ-ын хувьд онцгой анхаарал шаардсан бүлэг юм.⁶⁻¹⁰ Олон улсад хийгдсэн судалгаагаар олон төрлийн мансууруулах бодис хавсран хэрэглэх, метамфетамин хэрэглэх, бэлгийн эрсдэлт зан үйл болон БЗДХ-ын халдвар авах нь хоорондоо хамааралтай болохыг тогтоосон байна.⁸⁻¹²

Монгол Улсад хорих ангид ял эдэлж буй мансууруулах бодис хэрэглэгчдийн дундах БЗДХ-ын халдварын тархалт, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх мэдээлэл хомс хэвээр байна. Иймээс бид мансууруулах бодистой холбоотой асуудлын улмаас хорих ангид ял эдэлж хоригдлуудын дундах БЗДХ-ыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээний үр дүн, түүнтэй холбоотой зарим хүчин зүйлийг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааны сэдвийг сонгосон.

Зорилго: Мансууруулах бодистой холбоотой асуудлын улмаас хорих ангид ял эдэлж буй хоригдлуудын дундах БЗДХ-ыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээний үр дүн, түүнтэй холбоотой зарим хүчин зүйлийг судлах

Зорилт

1. Судалгаанд хамрагдсан хоригдлуудын хүн амзүйн үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлох
2. Хоригдлуудын дундах БЗДХ-тай холбоотой түүх, шинж тэмдэг, шинжилгээний хамрагдалт, сургалт мэдээллийн хүртээмжийг үнэлэх.
3. БЗДХ-ыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээний үр дүнг мансууруулах бодисын хэрэглээ, БЗДХ-аар өвдсөн түүх болон бусад хүчин зүйлстэй хамааруулан судлах

Арга, аргачлал:

Судалгааны загвар: Судалгааг агшингийн аналитик загвараар 2025 оны 3 дугаар сарын 1-нээс 2026 оны 1 дүгээр сарын 1-ний хооронд явуулсан.

Судалгааны хамрах хүрээ, оролцогчид: Судалгаанд хорих ангид ял эдэлж буй мансууруулах бодистой холбоотой асуудлын улмаас ял эдэлж буй, судалгаанд оролцохыг сайн дураараа зөвшөөрсөн 105 хоригдлыг хамруулав. Судалгаанд Зөвхөн согтууруулах ундаа, тамхи хэрэглэдэг, эсвэл судалгаанд оролцохоос татгалзсан хүмүүсийг хамруулаагүй.

Мэдээлэл цуглуулах хэрэгсэл: Судалгааны карт нь хүн амзүй, нийгэм-эдийн засгийн байдал, бодисын хэрэглээний хэв маяг, бэлгийн зан үйл, БЗДХ-аар өвдөж байсан эсэх, одоогоор зовуурь байгаа эсэх, шинжилгээний хамрагдалт, сургалт мэдээллийн хүртээмж зэргийг тодруулсан. Мөн мансууруулах бодисын хэрэглээний түвшинг тодорхойлох DAST стандарт асуумжийг ашигласан. Судалгаанд оролцогчийн зөвшөөрлийн дагуу өндөгний цусанд ХДХВ, *Treponema pallidum* үзэх түргэвчилсэн сорилыг хийхдээ ЭМС-ын 2023 оны А/133 тоот тушаалд заасан чанар, стандартыг хангасан мэдрэг болон өвөрмөц чанар өндөртэй ХДХВ, тэмбүүгийн халдвар илрүүлэх хосолсон хурдавчилсан оношлуурыг ашигласан. Хурдавчилсан шинжилгээний хариу эерэг гарсан тохиолдолд дараагийн шатны баталгаажуулах шинжилгээнд холбон зуучлах зохион байгуулалтыг хийсэн.

Статистик боловсруулалт: Өгөгдлийг Microsoft Excel болон SPSS 23 программд боловсруулж, дүрслэх статистикаар давтамж, хувь, дундаж, стандарт хазайлтыг тооцсон. Тэмбүүгийн түргэвчилсэн шинжилгээний эерэг хариутай холбоог үнэлэхдээ χ^2 тест болон Fisher-ийн exact тестийг хэрэглэв. Цөөн тохиолдолтой ангиллуудыг нэгтгэн шинжилж, зөвхөн тухайн хувьсагчийн хүчинтэй мэдээлэлтэй оролцогчдыг шинжилгээнд оруулав. Статистикийн ач холбогдлын түвшинг $p < 0.05$ гэж үнэлэв.

Ёс зүйн асуудал: Судалгааг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны зөвшөөрөл авч, (24-25/05-02). Оролцогчдоос таниулсан зөвшөөрөл авч, мэдээллийн нууцлалыг ханган ажиллав.

Үр дүн: Судалгаанд нийт 105 хоригдол хамрагдсаны дундаж нас 29.1 ± 8.4 байв. Насны бүтцийн хувьд 25–34 насныхан 55.2%-ийг, 18–24 насныхан 26.7%-ийг, 35–44 насныхан 11.4%-ийг, 45 ба түүнээс дээш насныхан 6.7%-ийг эзэлсэн. Нийт оролцогчдын 78.1% нь эрэгтэй, 21.9% нь эмэгтэй байлаа. Оролцогчдын дийлэнх нь гэрлээгүй байсан бөгөөд цөөнх хэсэг нь гэрлэсэн эсвэл хамтран амьдрагчтай байсан. Боловсролын түвшний хувьд бүрэн дунд боловсролтой оролцогчид зонхилж, ажил эрхлэлтийн байдлаар хоригдож байхаас өмнө тогтмол ажил эрхлээгүй болон тогтмол бус орлоготой хүмүүс харьцангуй өндөр хувийг эзэлж байв.

БЗДХ-тай холбоотой үзүүлэлтүүдийг авч үзэхэд оролцогчдын 16.2% нь өмнө нь БЗДХ авч байсан, 19.0% нь сүүлийн 12 сард БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн, 39.0% нь сүүлийн 12 сард БЗДХ-ын шинжилгээ өгсөн байв. Ял эдэлж байх хугацаанд БЗДХ-ын шинжилгээнд хамрагдсан хувь 45.7% байсан бол БЗДХ-ын талаарх

сургалт мэдээлэлд хамрагдсан хувь 79.0% байлаа. Мөн баривчлагдахаас өмнө тохиолдлын бэлгийн хавьталтай байсан оролцогч 34.3%, бэлгийн эрсдэлт зан үйлийн ерөнхий илрэл 13.3% байв.

Тэмбүүгийн түргэвчилсэн шинжилгээний хүчинтэй хариутай 81 оролцогчийн 27-д нь эерэг буюу тархалт 33.3% байв.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан хоригдлуудын хүн амзүйн үзүүлэлт, ХДХВ, тэмбүүг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээний хариу (n=81)

Хувьсагч	Үзүүлэлтүүд	SIP сөрөг n/N (%)	SIP эерэг n/N (%)	p утга
Хүйс	Эрэгтэй	44/64 (68.8)	20/64 (31.2)	0.564
	Эмэгтэй	10/17 (58.8)	7/17 (41.2)	
Насны бүлэг	18–24	14/19 (73.7)	5/19 (26.3)	0.582
	25 ба түүнээс дээш	40/62 (64.5)	22/62 (35.5)	
Боловсролын түвшин	Бүрэн дунд ба түүнээс доош	31/45 (68.9)	14/45 (31.1)	0.644
	Техник, МСҮТ ба түүнээс дээш	23/36 (63.9)	13/36 (36.1)	
Гэрлэлтийн байдал	Гэрлээгүй	27/39 (69.2)	12/39 (30.8)	0.814
	Гэрлэсэн/хамтран амьдарч байсан	27/42 (64.3)	15/42 (35.7)	
Хамтран амьдрагчтай эсэх	Үгүй	32/48 (66.7)	16/48 (33.3)	1.000
	Тийм	22/33 (66.7)	11/33 (33.3)	
Орлогын байдал	Тогтмол орлогогүй	15/20 (75.0)	5/20 (25.0)	0.424
	Орлоготой	39/61 (63.9)	22/61 (36.1)	

Хүн амзүйн болон нийгэм-эдийн засгийн зарим үзүүлэлтийг БЗДХ-ыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээний хариутай харьцуулан үзэхэд хүйс, насны бүлэг, боловсролын түвшин, гэрлэлтийн байдал, хамтран амьдрагчтай эсэх, орлогын байдал нь түргэвчилсэн шинжилгээний эерэг хариутай статистикийн ач холбогдолгүй байв. Тухайлбал, эрэгтэй оролцогчдын 31.2%, эмэгтэй оролцогчдын 41.2% нь эерэг гарсан боловч ялгаа статистикийн ач холбогдолгүй байлаа ($p=0.564$). Насны ангилаар авч үзэхэд 18–24 насны бүлгийн 26.3%, 25 ба түүнээс дээш насны бүлгийн 35.5% нь шинжилгээ эерэг байсан боловч ялгаа илрээгүй ($p=0.582$). Боловсролын түвшингээр үнэлэхэд бүрэн дунд ба түүнээс

доош боловсролтой оролцогчдын 31.1%, техник, мэргэжлийн болон түүнээс дээш боловсролтой оролцогчдын 36.1%-д нь сорил эерэг байсан бөгөөд статистикийн ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p=0.644$). Гэрлэлтийн байдлын хувьд гэрлээгүй оролцогчдын 30.8%, гэрлэсэн эсвэл хамтран амьдарч байсан оролцогчдын 35.7% нь эерэг байсан нь ач холбогдолгүй байв ($p=0.814$). Хамтран амьдрагчтай эсэхээр авч үзэхэд хоёр бүлгийн аль алинд нь эерэг хариу 33.3% байсан ($p=1.000$). Орлогын байдлыг нэгтгэн үнэлэхэд тогтмол орлогогүй оролцогчдын 25.0%, орлоготой оролцогчдын 36.1% нь эерэг гарсан боловч энэ ялгаа мөн статистикийн ач холбогдолгүй байв ($p=0.424$).

Хүснэгт 2. БЗДХ-ыг илрүүлэх түргэвчилсэн сорилын үр дүн, мансууруулах бодис хэрэглэх аргыг харьцуулсан үзүүлэлт (n=81)

Хувьсагч	Үзүүлэлт	SIP сөрөг n/N (%)	SIP эерэг n/N (%)	p утга	Тест
СИБ-ыг олон аргаар хэрэглэдэг	Үгүй	20/23 (87.0)	3/23 (13.0)	0.018	Fisher exact
	Тийм	34/58 (58.6)	24/58 (41.4)		
Тариур хэрэглэдэг эсэх	Үгүй	43/63 (68.3)	20/63 (31.7)	0.777	χ^2
	Тийм	11/18 (61.1)	7/18 (38.9)		
Тарьж хэрэглэдэг хэлбэрийн аль нэг	Үгүй	37/55 (67.3)	18/55 (32.7)	1.000	χ^2
	Тийм	17/26 (65.4)	9/26 (34.6)		
Өмнө нь БЗДХ-тай байсан түүх	Үгүй	47/64 (73.4)	17/64 (26.6)	0.011	Fisher exact
	Тийм	3/10 (30.0)	7/10 (70.0)		
Сүүлийн 12 сард БЗДХ-ын шинж тэмдэг	Үгүй	22/33 (66.7)	11/33 (33.3)	0.694	χ^2
	Тийм	9/16 (56.2)	7/16 (43.8)		
Баривчлагдахаас өмнө тохиолдлын бэлгийн хавьталд орсон эсэх	Үгүй	33/47 (70.2)	14/47 (29.8)	0.450	χ^2
	Тийм	19/32 (59.4)	13/32 (40.6)		
Бэлгийн эрсдэлт зан үйлийн илрэл	Үгүй	47/68 (69.1)	21/68 (30.9)	0.454	χ^2
	Тийм	7/13 (53.8)	6/13 (46.2)		

Хүснэгт 2-оос үзэхэд, бэлгийн эрсдэлт зан үйл болон БЗДХ-тай холбоотой зарим үзүүлэлтүүдтэй түргэвчилсэн шинжилгээний эерэг хариу нь статистикийн ач холбогдолтой холбоотой байв. Нэгээс олон төрлийн аргаар мансууруулах бодис хэрэглэдэг бүлэгт түргэвчилсэн шинжилгээ эерэг байх хувь 41.4%, нэг төрлийн аргаар мансууруулах бодис

хэрэглэгч бүлэгт 13.0%- байгаа нь статистикийн ач холбогдол бүхий ялгаатай байна ($p=0.018$). Мөн өмнө нь БЗДХ-аар өвдөж байсан асуумжтай оролцогчдын 70.0%-д түргэвчилсэн шинжилгээ эерэг гарсан бол БЗДХ-аар өвдөж байгаагүй оролцогчдын 26.6%-байгаа нь статистикийн ач холбогдолтой байв ($p=0.011$). Мансууруулах бодисыг тарьж хэрэглэдэг,

сүүлийн 12 сард БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн байдал, баривчлагдахаас өмнө тохиолдлын бэлгийн хавьтал болон бэлгийн эрсдэлт зан үйлийн илрэлтэй статистикийн ач холбогдол илрээгүй.

Дээрх үр дүнгээс харахад түргэвчилсэн сорил эерэг гарах нь хүн амзүй, нийгэм-эдийн засгийн суурь үзүүлэлтүүдээс илүүтэйгээр мансууруулах бодис хэрэглэх арга, өмнө нь БЗДХ-аар өвдөж байсан зэрэг үзүүлэлттэй холбоотой байх хандлагатай байна. Иймд хорих ангид ял эдэлж буй мансууруулах бодис хэрэглэгчдийн дунд БЗДХ-ын эрсдэлийг үнэлэхдээ зөвхөн нас, хүйс, боловсрол, гэрлэлтийн байдал зэрэг суурь хүчин зүйлсээр хязгаарлахгүйгээр, мансууруулах бодис хэрэглэх арга, БЗДХ-аар өвдөж байсан эсэх, бэлгийн эрсдэлт зан үйлийн үзүүлэлтүүдийг хамтатган үнэлэх нь зүйтэй.

Хэлцэмж: Энэхүү судалгаагаар хорих ангид ял эдэлж буй мансууруулах бодис хэрэглэгчдийн дунд БЗДХ-ыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ эерэг гарсан тохиолдол 33.3% байсан нь тархалт өндөртэй болохыг харуулж байна. Энэ үзүүлэлт нь Монгол Улсын нийт хүн амын дунд бүртгэгдсэн тэмбүүгийн өвчлөлийн түвшин, үндэсний тандалт судалгааны зарим эрсдэлт бүлгүүдээс өндөр байж болохоор байна.² Иймээс мансууруулах бодисын асуудалтай хорих ангид ял эдэлж байгаа хоригдлууд нь тэмбүүгийн халдварын эрсдэл өндөртэй бүлэг гэж үзэж болохоор байна.

Судалгааны гол ач холбогдолтой үр дүн нь мансууруулах бодисыг олон төрлийн арга ашиглан хэрэглэдэг, БЗДХ-аар өвдөж байсан зэрэг нь тэмбүүгийн түргэвчилсэн шинжилгээний эерэг хариутай статистикийн ач холбогдолтой байсан юм. Мансууруулах бодисыг олон төрлийн аргаар хэрэглэх нь бэлгийн эрсдэлт зан үйл, хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох, олон хавьтагчтай байх зэрэг тэмбүүгийн эрсдэлийг нэмэгдүүлж болохыг олон судалгаануудаар баталсан байна.^{3,8-12} Мөн мансууруулах бодисыг хавсран хэрэглэдэг хүмүүсийн бүлэгт ХДХВ, HCV, тэмбүүгийн халдвар хавсарсан байдлаар илэрсэн нь Хятад улсад хийгдсэн судалгааны үр дүнтэй дүйцэж байна.¹³

Өмнө нь БЗДХ-аар өвдөж байсан хоригдлуудын дунд БЗДХ-ыг илрүүлэх түргэвчилсэн сорилын эерэг гарсан хувь өндөр байсан нь бэлгийн эрсдэлт зан үйлийн тархалт өндөр болохыг харуулж байгаа ба энэ нь тарьж хэрэглэгчдийн дунд илүү өндөр байдаг гэсэн судалгааны үр дүнтэй мөн нийцэж байна.⁴⁻⁷

Харин хүйс, нас, боловсрол, гэрлэлтийн байдал, хамтран амьдрагчтай эсэх, орлогын байдал зэрэг хүн амзүйн болон нийгэм-эдийн засгийн суурь үзүүлэлтүүдтэй түргэвчилсэн шинжилгээний эерэг хариу статистикийн ач холбогдолгүй байв. Энэ нь хоригдлуудын дундах тэмбүүгийн тохиолдол нь суурь хүчин зүйл болох нийгэм-эдийн засгийн ялгаанаас илүүтэйгээр бодис хэрэглээ болон БЗДХ-аар өвдөж байсан эсэх зэрэг зан үйлийн хүчин зүйлтэй нягт

хамааралтай байж болохыг харуулж байна.

Хоригдлуудын 79.0% нь БЗДХ-ын талаарх сургалтанд хамрагдсан ч ял эдэлж байх хугацаанд БЗДХ-ын шинжилгээнд хамрагдсан хувь 45.7% байсан нь мэдээллийн хүртээмж, эмнэлгийн тусламжийн хооронд зөрүү байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл зөвхөн сургалт явуулах нь хангалтгүй, харин хорих ангиудад эрүүл мэндийн үзлэгийг тогмолжуулах, эрт илрүүлэг, зөвлөгөө, түргэвчилсэн шинжилгээ, баталгаажуулах оношилгоог илүү идэвхтэй зохион байгуулах шаардлагатай гэж үзэж болохоор байна. Бидний судалгааны үр дүнтэй төстэй үр дүн мансууруулах бодис тарьж хэрэглэгчдийн дундах БЗДХ-ын шинжилгээний хамрагдалтыг судалсан тойм судалгаанд ч дурьдагдсан байдаг.¹⁴

Түүнчлэн манай судалгаанд мансууруулах бодисыг тарьж хэрэглэдэг, сүүлийн 12 сард БЗДХ-ын шинж тэмдэг илэрсэн, баривчлагдахаас өмнөх тохиолдлын бэлгийн хавьталд орсон зэрэг үзүүлэлтүүдтэй статистикийн ач холбогдолтой холбоо илрээгүй. Энэ нь асуумжинд дутуу болон буруу мэдээлэл өгөх, мөн түргэвчилсэн шинжилгээ эерэг оролцогчдын тоо хязгаарлагдмал байсантай холбоотой байж болно.

Энэхүү судалгааны давуу тал нь хорих ангид ял эдэлж буй мансууруулах бодис хэрэглэгчдийн дунд БЗДХ-ын түргэвчилсэн шинжилгээ болон бэлгийн эрсдэлт зан үйлийн талаарх мэдээллийг нэгтгэн үнэлсэнд оршино. Харин хязгаарлагдмал тал нь агшингийн загвараар хийсэн тул шалтгаан холбоо тогтоох боломжгүй, зарим хувьсагчид дутуу мэдээлэлтэй, БЗДХ болон зан үйлийн зарим үзүүлэлт нь өөрөө тайлагнасан мэдээлэлд тулгуурласан, мөн түргэвчилсэн шинжилгээ нь баталгаажуулах оношлогооны өмнөх илрүүлгийн шатны үзүүлэлт гэдгээр хязгаарлагдана.

Дүгнэлт: Хорих ангид ял эдэлж буй мансууруулах бодис хэрэглэгчдийн дунд тэмбүүгийн түргэвчилсэн шинжилгээ 33.3% -д эерэг байсан нь энэ бүлэгт тэмбүүгийн эрсдэл өндөр байгааг харуулж байна. Мансууруулах бодисыг олон аргаар хэрэглэдэг, өмнө нь БЗДХ-аар өвдөж байсан зэрэг нь тэмбүүгийн түргэвчилсэн шинжилгээний эерэг хариутай статистикийн ач холбогдолтой байв. Харин хүн амзүйн суурь үзүүлэлтүүдтэй статистикийн ач холбогдол бүхий хамаарал илрээгүй. БЗДХ-ын талаарх сургалт мэдээллийн хамрагдалт өндөр байсан ч шинжилгээний хамрагдалт бага байсан нь хорих ангийн орчинд илрүүлэг, зөвлөгөө, баталгаажуулах шинжилгээ, эмчилгээ үйлчилгээг зорилтот байдлаар сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Ном зүй

1. United Nations Office on Drugs and Crime. World Drug Report 2025: Key Findings. Vienna, Austria: United Nations Office on Drugs and Crime; 2025.
2. Эрүүл мэндийн хөгжлийн төв. Эрүүл мэндийн үзүүлэлт 2023. Улаанбаатар, Монгол Улс: Эрүүл мэндийн хөгжлийн төв; 2024.
3. Leigh BC, Stall R. Substance use and risky sexual behavior for exposure to HIV: issues in methodology, interpretation, and

- prevention. *Am Psychol*. 1993;48(10):1035-1045.
4. Brookmeyer KA, Haderxhanaj LT, Hogben M, Leichter JS. Sexual risk behaviors and STDs among persons who inject drugs: a national study. *Prev Med*. 2019;126:105779.
 5. Kanno MB, Hooton TM, Roberts PL, Stamm WE, Holmes KK. Sexually transmitted diseases in injection drug users. *Infect Dis Clin North Am*. 2002;16(3):681-698.
 6. Nelson KE, Vlahov D, Solomon L, Cohn S, Mucoz A. Sexually transmitted diseases in a population of intravenous drug users: association with seropositivity to the human immunodeficiency virus. *J Infect Dis*. 1991;164(3):457-463.
 7. Ross MW, Wodak A, Darke S, Hall W. Sexually transmissible diseases in injecting drug users. *Genitourin Med*. 1991;67(1):32-36.
 8. Hittner JB, Owens EC. Meta-analysis of the association between methamphetamine use and high-risk sexual behavior among heterosexuals. *Psychol Addict Behav*. 2016;30(1):147-157.
 9. Taylor MM, Aynalem G, Smith LV, Montoya JA, Kerndt PR. Methamphetamine use and sexual risk behaviours among men who have sex with men diagnosed with early syphilis in Los Angeles County. *Int J STD AIDS*. 2007;18(2):93-97.
 10. Halkitis PN, Mukherjee PP, Palamar JJ. Longitudinal modeling of methamphetamine use and sexual risk behaviors in gay and bisexual men. *AIDS Behav*. 2009;13(4):783-791.
 11. Fisher DG, Reynolds GL, Ware MR, Napper LE. Methamphetamine and Viagra use: relationship to sexual risk behaviors. *Arch Sex Behav*. 2011;40(2):273-279.
 12. del Pozo-Herce P, Baca-Garcia E, Martinez-Sabater A, Chover-Sierra E, Gea-Caballero V, Curto-Ramos J, et al. Descriptive study on substance uses and risk of sexually transmitted infections in the practice of Chemsex in Spain. *Front Public Health*. 2024;12:1391390. doi:10.3389/fpubh.2024.1391390.
 13. Su S, Mao L, Zhao J, Chen L, Jing J, Cheng F, et al. Epidemics of HIV, HCV and syphilis infection among synthetic drugs only users, heroin-only users and poly-drug users in Southwest China. *Sci Rep*. 2018;8:6615. doi:10.1038/s41598-018-25038-y.
 14. Price O, Webb P, Grebely J, Peacock A, Medland N, Read P, et al. Sexually transmitted infection prevalence and testing coverage among people who inject drugs: A systematic review. *Drug Alcohol Depend*. 2025;276:112732. doi:10.1016/j.drugalcdep.2025.112732.

Some rapid test results for detecting sexually transmitted infections among inmates serving sentences for drug-related offenses

Minjmaa E¹, Bilguun N¹, Oyunsuren D¹, Tergel Kh¹, Davaalkham J², Khishigsuren Z¹

¹Department of Mental Health, School of Medicine, Mongolian National University of Medical Sciences

²HIV/STI Surveillance and Research Division, National Center for Communicable Diseases

E-mail: Dr.minjmaa87@gmail.com, Tel: +976-99711658

Abstract

Background: Drug use is closely associated with sexually transmitted infections, especially syphilis and HIV, through unsafe sexual practices, multiple partners, and high-risk patterns of substance use. Prisoners with a history of drug use represent a particularly vulnerable subgroup.

Aim: This study aimed to determine the prevalence of rapid syphilis test positivity and selected associated factors among incarcerated people who use drugs.

Materials and Methods: A cross-sectional analytic study was conducted among 105 prisoners. Data were collected using a structured questionnaire and a finger-prick rapid dual test. Descriptive statistics, chi-square tests, and Fisher exact tests were used, with $p < 0.05$ considered statistically significant.

Results: The mean age of participants was 29.1 ± 8.4 years; 78.1% were male. A history of STI was reported by 16.2%, STI-related symptoms during the last 12 months by 19.0%, STI testing during the last 12 months by 39.0%, and STI testing while incarcerated by 45.7%. However, 79.0% had received STI-related education or information. Among 81 participants with valid rapid syphilis test results, 27 were positive, giving a prevalence of 33.3%. Syphilis positivity was significantly higher among those using more than one route of drug administration (41.4% vs 13.0%, $p = 0.018$) and among those with a prior STI history (70.0% vs 26.6%, $p = 0.011$). No significant associations were found with sex, age, education, marital status, cohabitation, income, syringe use, recent STI symptoms, casual sex before arrest, or overall sexual risk behavior.

Conclusion: These findings suggest that targeted syphilis screening, counseling, and linkage to confirmatory testing and treatment should be strengthened among incarcerated people who use drugs, particularly those with multi-route drug use and a previous STI history.

Key words: prisoner, people who use drugs, syphilis, sexually transmitted infection, rapid test